ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

**АУДИТЫН КОД:СНАГ-2024/70/НА-СТА-ТШЗ**

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

**Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг**
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
**Аудитын менежер: Ц.Хосжаргал**
Утас: 261663 Цахим хаяг: khosjargalts@audit.gov.mn
**Ахлах аудитор: Д.Болор-Эрдэнэ**
Утас: 261740 Цахим хаяг: bolor-erdened@audit.gov.mn
**Аудитор: Б.Ариунжаргал**
Утас: 261740 Цахим хаяг: ariunjargalb@audit.gov.mn

Улаанбаатар хот
2024 он

Агуулга


1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .......... 3

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .......... 5

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .......... 5

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .......... 6

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .......... 8

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .......... 9

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .......... 11

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .......... 13

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .......... 14

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .......... 14

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .......... 14

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .......... 15

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .......... 16

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .......... 17

3.5.1 Төсвийн төлөвлөлт .......... 17

3.5.2 Төсвийн гүйцэтгэл .......... 17

3.5.3 Нэмэлт төсөв .......... 18

4. АУДИТЫН ТАЙЛАН .......... 19

4.1 Ерөнхий зүйл .......... 19

4.2 Материаллаг байдал .......... 19

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .......... 19

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .......... 19

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд .......... 20

4.5 Засврын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .......... 20

4.5.1 Засврын аудитын талаар .......... 20

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн .......... 20

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .......... 20

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .......... 21

5.1 Албан шаардлага .......... 21

5.3 Зөвлөмж .......... 23

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .......... 26

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| БНСУ | Бүгд Найрамдах Солонгос Улс |
| ЗГ | Засгийн газар |
| СНАГ | Санхүү-нийцлийн аудитын газар |
| ТНБД | Төрийн нарийн бичгийн дарга |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| НДЕГ | Нийгмийн даатгалын ерөнхий газар |
| НҮБ | Нэгдсэн үндэсний байгууллага |
| ОУБ | Олон улсын байгууллага |
| ҮСХ | Үндэсний статистикийн хороо |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| ХХҮЕГ | Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын |
| ХНХС | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд |
| ХЭДС | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан |

УНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.02.23 № 07/331

танай ___________-ны № ___________-т

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ З.ЭНХБОЛД ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн дараах залруулагдаагүй алдаа, зөрчил тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн, толилуулга, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна. Үүнд:

- Санхүүгийн тайланд бүртгэлтэй 324,858.7 мянган төгрөгийн бараа материал, 8,368,029.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөд жилийн эцсийн тооллого хийж баталгаажуулаагүй;
- Худалдан авах ажиллагааны босго үнийг баримтлаагүй, 71,000.0 мянган төгрөгийн нэг төрлийн бараа, ажил үйлчилгээг шууд худалдан авсан;
- Үр дүнгийн урамшууллыг албан хаагчдад хавтгайруулан олгож, 110,021.1 мянган төгрөгийн төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан;
- Бараа материалын тайланд 331,854.0 мянган төгрөгийн бараа материалын хөдөлгөөнийг буруу бүртгэсэн;
- Анхан шатны баримтын бүрдэлгүй, нотлох баримтын шаардлага хангахгүй 17,112.0 мянган төгрөгийн ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч, бүртгэлд тусгасан;

- Өмнөх аудитаар хүргүүлсэн албан шаардлагын хэрэгжилтийг хангаагүй, 105,882.8 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргасан

зэрэг зөрчил нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 5.1.4, 12 дугаар зүйлийн 12.1, 12.2, 12.2.1, 13 дугаар зүйлийн 13.7, 19 дүгээр зүйлийн 19.1, 20 дугаар зүйлийн 20.2.3, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, 8.5, 34 дүгээр зүйлийн 34.1.3, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, 15.2.3 дахь заалтуудтай тус тус нийцээгүй.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны Б/26, 2020 оны Б/36, 2023 оны Б/03, Б/32, Б/45 дугаар 5 удаагийн тушаалаар 2019 оноос хойш Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр 5 албан тушаалтан томилогдож, хүний нөөцийн тогтвортой байдал алдагдсан байна.

**Аудитын гол асуудал**

Засгийн газрын 2016 оны "Засгийн газрын агентлагийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 4 дүгээр тогтоолоор тус газрын орон тооны дээд хязгаарыг 67 байхаар баталж, батлагдсан орон тоонд тусгагдаагүй 9 төрийн үйлчилгээний ажилтныг 2019 оноос хойш ажиллуулсаар байгаа нь өмнөх аудитаар хүргүүлсэн зөрчлийг арилгах албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

**Бусад асуудлын хэсэг**

Тайлант онд 2 хөтөлбөр, 24 зорилт, 98 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас гүйцэтгэлээр 17 арга хэмжээг 100.0 хувь, 50 арга хэмжээг 90.0 хувь, 23 арга хэмжээг 70.0 хувь, 6 арга хэмжээг 50.0 хувь, 2 арга хэмжээг 30.0 хувь буюу нийт дүнгээр 83.4 хувиар үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гараагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *\/төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **361,249,608.42** | **364,571,570.23** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **3,791,733.40** | **5,376,859.53** |
| **31200** | **Банканд байгаа бэлэн мөнгө** | **3,791,733.40** | **5,376,859.53** |
| **31210** | **Төгрөг** | **3,000,200.00** | **1,750,000.00** |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 3,000,000.00 | 1,750,000.00 |
| 31213 | Арилжааны банк дахь харилцах | 200.00 | - |
| **31220** | **Гадаад валют** | **791,533.40** | **3,626,859.53** |
| 31223 | Арилжааны банк дахь харилцах | 791,533.40 | 3,626,859.53 |
| **33** | **АВЛАГА** | **20,837,464.21** | **34,336,032.96** |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 244,028.00 | 244,028.00 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | - | 21,187,455.33 |
| **33500** | **Бусад авлага** | **20,593,436.21** | **12,904,549.63** |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 7,688,886.58 | - |
| 33520 | Хувь хүмүүсээс авах авлага | 12,904,549.63 | 12,904,549.63 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **336,620,410.81** | **324,858,677.74** |
| **35400** | **Хангамжийн материал** | **336,620,410.81** | **324,858,677.74** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 7,021,236.00 | 5,919,736.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 25,069,686.00 | 25,069,686.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 25,461,700.00 | 24,959,200.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 279,067,788.81 | 268,910,055.74 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **7,087,148,298.82** | **8,368,029,811.79** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **7,087,148,298.82** | **8,368,029,811.79** |
| **39200** | **Биет хөрөнгө** | **6,280,502,836.50** | **5,474,335,003.66** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 5,485,177,953.00 | 5,478,292,733.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (428,187,297.12) | (533,583,269.40) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 117,918,700.00 | 117,918,700.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (65,540,876.36) | (76,193,993.00) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 4,549,458,105.16 | 4,393,806,458.28 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (3,378,634,293.49) | (3,913,163,257.49) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 378,087,124.46 | 382,545,587.52 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (377,776,579.15) | (378,884,280.21) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | - | 4,795,100.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | - | (1,198,775.04) |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | **806,645,462.32** | **2,893,694,808.13** |
| 39301 | Программ хангамж | 2,588,958,714.90 | 5,457,194,227.90 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,806,080,172.58) | (2,587,266,339.77) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 303,025,080.00 | 303,025,080.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | (279,258,160.00) | (279,258,160.00) |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **7,448,397,907.24** | **8,732,601,382.02** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **12,904,549.63** | **23,454,557.96** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **12,904,549.63** | **23,454,557.96** |
| **41300** | **Өглөг** | **12,904,549.63** | **23,454,557.96** |
| **41360** | **Бусад өглөг** | **12,904,549.63** | **23,454,557.96** |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | - | 10,550,008.33 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 12,904,549.63 | 12,904,549.63 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **7,435,493,357.61** | **8,709,146,824.06** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **7,435,493,357.61** | **8,709,146,824.06** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 23,766,920.00 | 23,766,920.00 |
| 511001 | Улсын төсвийн оруулсан хөрөнгө | 23,766,920.00 | 23,766,920.00 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **5,324,798,837.06** | **6,598,452,303.51** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 6,138,845,531.66 | 5,317,109,950.48 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | (814,046,694.60) | 1,281,342,353.03 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 2,086,927,600.55 | 2,086,927,600.55 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **7,448,397,907.24** | **8,732,601,382.02** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **3,310,939,943.33** | **8,661,048,091.36** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,504,147,833.33** | **5,139,253,479.36** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **1,504,147,833.33** | **5,139,253,479.36** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **855,238,671.00** | **1,926,091,560.92** |
| 1E+06 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 702,037,509.00 | 1,914,692,743.76 |
| 1E+06 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 153,201,162.00 | 11,398,817.16 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 639,449,162.33 | 3,210,700,918.44 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 9,460,000.00 | 2,461,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,806,792,110.00** | **3,521,794,612.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **1,787,562,110.00** | **2,480,886,533.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,787,562,110.00 | 2,480,886,533.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **19,230,000.00** | **1,040,908,079.00** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 19,200,000.00 | 1,040,908,079.00 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **4,102,221,067.37** | **7,136,637,926.30** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **4,102,221,067.37** | **7,136,637,926.30** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **3,220,966,447.28** | **5,201,931,995.47** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,070,716,160.33** | **1,599,099,255.44** |
| 210101 | Үндсэн цалин | 713,332,998.39 | 907,710,520.08 |
| 210102 | Нэмэгдэл | 288,752,635.69 | 300,095,616.19 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 68,630,526.25 | 211,467,613.52 |
| 210104 | Урамшуулал | - | 176,671,164.05 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | - | 3,154,341.60 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **139,166,297.23** | **202,204,621.99** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 98,143,025.13 | 141,106,899.59 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 9,877,319.50 | 15,241,670.54 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,887,066.67 | 12,381,342.54 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,239,685.93 | 3,447,516.10 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 21,019,200.00 | 30,027,193.22 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **111,760,493.11** | **145,924,230.28** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 83,020,591.33 | 103,442,401.32 |
| 210302 | Түлш, халаалт | 19,515,026.78 | 25,290,443.79 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 9,224,875.00 | 11,351,385.17 |
| 210304 | Байрны түрээс | 0 | 5,840,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **58,221,849.24** | **400,897,638.73** |
| 210401 | Бичиг хэрэг | 21,092,600.00 | 87,485,050.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 9,034,800.00 | 255,606,734.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 11,201,342.14 | 31,851,301.73 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,338,500.00 | 2,040,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 15,554,607.10 | 23,914,553.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **19,883,300.00** | **32,325,100.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 6,847,000.00 | 2,683,300.00 |
| 210604 | Урсгал засвар | 10,836,300.00 | 29,641,800.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **13,739,444.00** | **135,095,080.30** |
| 210702 | Дотоод албан томилолт | 8,044,244.00 | 131,634,980.30 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 5,695,200.00 | 3,460,100.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **371,336,740.00** | **784,197,172.21** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 347,003,920.00 | 746,865,009.21 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | - | 241,110.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 150,000.00 | 1,627,108.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 99,000.00 | 55,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 14,736,450.00 | 29,345,250.00 |

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01
ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 210807 | Газрын төлбөр | 517,770.00 | 1,736,095.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | - | 200 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 8,829,600.00 | 4,327,400.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **1,436,142,163.37** | **1,902,188,896.52** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 233,533,134.99 | 20,146,220.07 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 324,000.00 | 166,287,592.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 1,202,285,028.38 | 1,715,755,084.45 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **881,254,620.09** | **1,934,705,930.83** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **92,719,869.00** | **116,992,537.00** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 77,685,433.00 | 39,764,233.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 15,034,436.00 | 77,228,304.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **788,534,751.09** | **1,817,713,393.83** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 113,932,427.09 | 99,392,852.85 |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 30,000.00 | 1,675,298.02 |
| 213306 | Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг | 674,572,324.00 | 1,716,645,242.96 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **(791,281,124.04)** | **1,524,410,165.06** |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **22,765,570.56** | **243,067,812.03** |
| 225001 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз | 22,765,570.56 | 239,504,321.00 |
| 225004 | Гадаад валютын ханшийн зөрүүний гарз | - | 3,563,491.03 |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **(814,046,694.60)** | **1,281,342,353.03** |
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **3,310,939,943.33** | **8,661,048,091.36** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,504,147,833.33** | **5,139,253,479.36** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **23,766,920.00** | **2,086,927,600.55** | **6,138,845,532.34** | **8,249,540,052.89** |
| **Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт** | **-** | **-** | **(0.68)** | **(0.68)** |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **23,766,920.00** | **2,086,927,600.55** | **6,138,845,531.66** | **8,249,540,052.21** |
| **Тайлант үеийн үр дүн** | - | - | (814,046,694.60) | (814,046,694.60) |
| **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **23,766,920.00** | **2,086,927,600.55** | **5,324,798,837.06** | **7,435,493,357.61** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | (7,688,886.58) | (7,688,886.58) |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **23,766,920.00** | **2,086,927,600.55** | **5,317,109,950.48** | **7,427,804,471.03** |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 1,281,342,353.03 | 1,281,342,353.03 |
| **2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл** | **23,766,920.00** | **2,086,927,600.55** | **6,598,452,303.51** | **8,709,146,824.06** |

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01
ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,662,030,780.89** | **5,458,436,181.25** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **855,238,670.89** | **1,936,641,569.25** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **855,238,670.89** | **1,936,641,569.25** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **855,238,670.89** | **1,936,641,569.25** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 702,037,509.00 | 1,925,242,752.09 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 153,201,161.89 | 11,398,817.16 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,806,792,110.00** | **3,521,794,612.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **1,787,562,110.00** | **2,480,886,533.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,787,562,110.00 | 2,480,886,533.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **19,230,000.00** | **1,040,908,079.00** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 19,200,000.00 | 1,040,908,079.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 30,000.00 | - |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **2,669,867,884.00** | **5,427,847,564.11** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,669,867,884.00** | **5,427,847,564.11** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,788,613,263.91** | **3,471,954,177.95** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,070,779,160.33** | **1,599,099,255.47** |
| 210101 | Үндсэн цалин | 713,395,998.39 | 907,710,520.08 |
| 210102 | Нэмэгдэл | 288,752,635.69 | 300,095,616.19 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 68,630,526.25 | 211,467,613.55 |
| 210104 | Урамшуулал | - | 176,671,164.05 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | - | 3,154,341.60 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **139,166,297.23** | **202,204,621.96** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 98,143,025.13 | 141,106,899.59 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 9,877,319.50 | 15,241,670.54 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,887,066.67 | 12,381,342.54 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,239,685.93 | 3,447,516.10 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 21,019,200.00 | 30,027,193.19 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **111,760,493.11** | **145,924,230.28** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 83,020,591.33 | 103,442,401.32 |
| 210302 | Түлш, халаалт | 19,515,026.78 | 25,290,443.79 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 9,224,875.00 | 11,351,385.17 |
| 210304 | Байрны түрээс | - | 5,840,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **58,221,849.24** | **397,474,325.73** |
| 210401 | Бичиг хэрэг | 21,092,600.00 | 84,483,950.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 9,034,800.00 | 255,606,734.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 11,201,342.14 | 31,851,301.73 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,338,500.00 | 2,040,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 15,554,607.10 | 23,492,340.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **19,883,300.00** | **38,721,900.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 6,847,000.00 | 9,080,100.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 2,200,000.00 | 0.00 |
| 210604 | Урсгал засвар | 10,836,300.00 | 29,641,800.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **13,739,444.00** | **135,095,080.30** |
| 210702 | Дотоод албан томилолт | 8,044,244.00 | 131,634,980.30 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 5,695,200.00 | 3,460,100.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **356,892,370.00** | **784,197,172.21** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 332,559,550.00 | 746,865,009.21 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | - | 241,110.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 150,000.00 | 1,627,108.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 99,000.00 | 55,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 14,736,450.00 | 29,345,250.00 |
| 210807 | Газрын төлбөр | 517,770.00 | 1,736,095.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | - | 200.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 8,829,600.00 | 4,327,400.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **18,170,350.00** | **169,237,592.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 17,846,350.00 | 2,950,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 324,000.00 | 166,287,592.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **881,254,620.09** | **1,955,893,386.16** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **92,719,869.00** | **116,992,537.00** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 77,685,433.00 | 39,764,233.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 15,034,436.00 | 77,228,304.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **788,534,751.09** | **1,838,900,849.16** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 113,932,427.09 | 219,097,355.18 |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 30,000.00 | 12,312,745.02 |
| 213306 | Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг | 674,572,324.00 | 1,607,490,748.96 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **(7,837,103.11)** | **30,588,617.14** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **-** | **25,439,999.98** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **25,439,999.98** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **-** | **25,439,999.98** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | - | 25,439,999.98 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **-** | **(25,439,999.98)** |
| **VII** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН** | **-** | **(3,563,491.03)** |
| **25** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ** | **-** | **3,563,491.03** |
| 250001 | Гадаад валютын ханшийн зөрүүний гарз | - | 3,563,491.03 |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **(7,837,103.11)** | **1,585,126.13** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 11,628,836.51 | 3,791,733.40 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 3,791,733.40 | 5,376,859.53 |

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01 ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **2,646,196,600.00** | **2,616,488,559.95** | **29,708,040.05** | 98.9 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,646,196,600.00** | **2,616,488,559.95** | **29,708,040.05** | 98.9 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,597,155,000.00 | 2,531,470,147.95 | 65,684,852.05 | 97.5 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,590,497,300.00 | 1,589,824,255.47 | 673,044.53 | 100.0 |
| 210101 | Үндсэн цалин | 1,019,142,500.00 | 898,435,520.08 | 120,706,979.92 | 88.2 |
| 210102 | Нэмэгдэл | 370,969,400.00 | 300,095,616.19 | 70,873,783.81 | 80.9 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 94,527,200.00 | 211,467,613.55 | (116,940,413.55) | 223.7 |
| 210104 | Урамшуулал | 105,858,200.00 | 176,671,164.05 | (70,812,964.05) | 166.9 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | - | 3,154,341.60 | (3,154,341.60) | - |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **250,641,600.00** | **200,879,621.96** | **49,761,978.04** | 80.1 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 166,275,300.00 | 139,781,899.59 | 26,493,400.41 | 84.1 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 21,091,200.00 | 15,241,670.54 | 5,849,529.46 | 72.3 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 16,873,000.00 | 12,381,342.54 | 4,491,657.46 | 73.4 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,217,700.00 | 3,447,516.10 | 770,183.90 | 81.7 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 42,184,400.00 | 30,027,193.19 | 12,157,206.81 | 71.2 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **149,321,800.00** | **145,924,230.28** | **3,397,569.72** | 97.7 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 103,504,100.00 | 103,442,401.32 | 61,698.68 | 99.9 |
| 210302 | Түлш, халаалт | 26,166,500.00 | 25,290,443.79 | 876,056.21 | 96.7 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 13,801,200.00 | 11,351,385.17 | 2,449,814.83 | 82.2 |
| 210304 | Байрны түрээс | 5,850,000.00 | 5,840,000.00 | 10,000.00 | 99.8 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **63,233,800.00** | **61,299,985.73** | **1,933,814.27** | 96.9 |
| 210401 | Бичиг хэрэг | 27,114,400.00 | 27,110,750.00 | 3,650.00 | 100.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,385,500.00 | 2,842,594.00 | 542,906.00 | 84.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 13,090,600.00 | 11,814,301.73 | 1,276,298.27 | 90.3 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,121,700.00 | 2,040,000.00 | 81,700.00 | 96.1 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 17,521,600.00 | 17,492,340.00 | 29,260.00 | 99.8 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **26,688,800.00** | **26,521,900.00** | **166,900.00** | 99.4 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 6,978,000.00 | 6,880,100.00 | 97,900.00 | 98.6 |
| 210604 | Урсгал засвар | 19,710,800.00 | 19,641,800.00 | 69,000.00 | 99.6 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **45,730,600.00** | **42,195,182.30** | **3,535,417.70** | 92.3 |
| 210701 | Гадаад албан томилолт | - | - | - | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 42,230,600.00 | 38,735,082.30 | 3,495,517.70 | 91.7 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 3,500,000.00 | 3,460,100.00 | 39,900.00 | 98.9 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **443,256,000.00** | **437,674,972.21** | **5,581,027.79** | 98.7 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 404,332,600.00 | 400,343,009.21 | 3,989,590.79 | 99.0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 324,600.00 | 241,110.00 | 83,490.00 | 74.3 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,902,500.00 | 1,627,108.00 | 275,392.00 | 85.5 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 102,900.00 | 55,000.00 | 47,900.00 | 53.4 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 29,744,100.00 | 29,345,250.00 | 398,850.00 | 98.7 |
| 210807 | Газрын төлбөр | 1,774,500.00 | 1,736,095.00 | 38,405.00 | 97.8 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 747,400.00 | - | 747,400.00 | - |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 4,327,400.00 | 4,327,400.00 | - | 100.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **27,785,100.00** | **27,150,000.00** | **635,100.00** | 97.7 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 27,785,100.00 | 27,150,000.00 | 635,100.00 | 97.7 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **49,041,600.00** | **85,018,412.00** | **(35,976,812.00)** | 173.4 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 49,041,600.00 | 48,071,033.00 | 970,567.00 | 98.0 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 40,724,300.00 | 39,764,233.00 | 960,067.00 | 97.6 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 8,317,300.00 | 8,306,800.00 | 10,500.00 | 99.9 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **2,646,196,600.00** | **2,616,488,559.95** | **29,708,040.05** | **98.9** |
| **31** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **2,481,846,600.00** | **2,418,441,059.15** | **63,405,540.85** | 97.4 |
| 310001 | Улсын төсвөөс санхүүжих | 2,481,846,600.00 | 2,418,441,059.15 | 63,405,540.85 | 97.4 |
| 35 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 164,350,000.00 | 198,047,500.80 | (33,697,500.80) | 120.5 |
| **350001** | **Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих** | **164,350,000.00** | **198,047,500.80** | **(33,697,500.80)** | 120.5 |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1 | 1 | - | 100.0 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 | - | 100.0 |
| 62 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 72 | 72 | - | 100.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | - | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 62 | 62 | - | 100.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 9 | 9 | - | 100.0 |

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | **1,040,908,079.00** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | | 1,040,908,079.00 |
| 210101 | Үндсэн цалин | | 9,275,000.00 |
| 210201 | Нийгмийн даатгалын шимтгэл | | 1,325,000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | | 57,373,200.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 252,238,140.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэт | | 20,563,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, | | 6,000,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | 26,999,999.98 |
| 210602 | Тавилга | | 640,000.00 |
| 210604 | Урсгал засвар | | 10,000,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | | 92,899,898.00 |
| 210801 | Бусад нийтлэг АҮТХураамж | | 346,522,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага х | | 139,266,400.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шаг урам | | 65,492,696.00 |
| 261090 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 12,312,745.02 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | | 139,266,400.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 139,266,400.00 |
| 210902 | Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх | | 139,266,400.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | | **1,040,908,079.00** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | | 864,793,885.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 63,686,200.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 112,427,994.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | - |
| 11000 | Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл | | - |
| 12000 | Мөнгөн хөрөнгийн оны эцсийн үлдэгдэл | | - |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 БАЙГУУЛЛАГА, ТҮҮНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь үйл ажиллагааны эрхэм зорилгоо "Хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн боловсрол, нийгмийн халамжийн үйл ажиллагааны төрөл, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх замаар иргэдийг ажилтай, орлоготой болгох, ядуурлыг бууруулах, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудын үйл ажиллагааг чанаржуулах, Монгол хүний амьдралын чанарыг сайжруулахад оршино" гэж тодорхойлсон байна.

Тус газар нь үйл ажиллагааны эрхэм зорилгын хүрээнд дор дурдсан тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлж байна. Үүнд:

- Хүн амын хөдөлмөрлөх эрхийг хангах боломж, нөхцөлийг бүрдүүлж, ажиллах хүчний мэргэжлийн ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх замаар хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг тэнцвэржүүлэн зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж ядуурлын түвшнийг бууруулах;
- Үндэсний хөдөлмөр эрхлэлт, халамжийн үйлчилгээний бодлогын хэрэгжилтийг дэлхийн жишигт хүргэн хөгжүүлэх;
- Нэг цонхны бодлогоор Монгол Улсын иргэдийн дотоод, гадаадын мэргэшсэн хүний нөөцийн зах зээлд гарах гарц нь болох;
- Төрийн үйлчилгээг ил тод, нээлттэй, тэгш шударга, чанартай хүргэх чадварыг байнга дээшлүүлсэн суралцагч байгууллагыг хөгжүүлэх, стратегийн төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын чадамжийг дээшлүүлэх;
- Байгууллагын гадаад, дотоод харилцааг хөгжүүлж салбарын бодлогыг хэрэгжүүлэх, хүний нөөцийг чадавхыг дээшлүүлэх талаар хамтран ажиллах, төр, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх;
- Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний цахим мэдээллийн нэгдсэн сүлжээг боловсронгуй болгож, төрийн зохих байгууллагуудын сүлжээ, мэдээлэлтэй нэгдмэл байдлыг хангах.

### 3.2 БАЙГУУЛЛАГЫН ГАДААД, ДОТООД ОРЧИН

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын стратегийн мөн чанар нь "Хүн амын хөгжлийг хангах таатай орчныг бүрдүүлэх, амьдралын чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ур чадвар эзэмшүүлэх, нийгмийн халамж, хамгааллын бодлого, арга хэмжээний хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулах, үйлчлүүлэгч төвтэй, мэргэшсэн чадварлаг, ёс зүйг дээдэлсэн манлайлагч байгууллага болно." гэж тодорхойлсны дагуу дараах зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, дүрэм, журмын хэрэгжилтийг зохион байгуулах ажлын уялдаа холбоог хангах, төрийн захиргааны удирдлагын манлайлал, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, төрийн үйлчилгээний чанарыг сайжруулах замаар үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг тасралтгүй дээшлүүлэх, дотоод, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх;
- Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлж, хамрах хүрээг өргөжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хүртээмж, чанар, үр ашгийг дээшлүүлж тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, хөдөлмөрлөх таатай нөхцөл боломжийг бүрдүүлэх замаар ажилгүйдэл, ядуурлыг бууруулж, хүн амын амьжиргааны түвшнийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- Хүн амын зорилтот бүлгүүдийн хэрэгцээнд нийцсэн нийгмийн халамжийн үйлчилгээний чанар, үр ашгийг дээшлүүлэх замаар тэдний нийгмийн хамгааллыг сайжруулах, нийгмийн баталгааг хангахад чиглэсэн хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, нийгмийн халамж хүртэгчээс хөдөлмөр эрхлэгч болох нөхцөлийг бүрдүүлэх, ядуурлын түвшнийг бууруулах;
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийгмийн халамжийн үйлчилгээний мэдээллийн нэгдсэн системийн хэвийн найдвартай ажиллагааг хангаж, бодлогын зохицуулалт боловсруулах, салбарын мэдээллийн нэгдсэн сүлжээг орчин үеийн шаардлагад нийцүүлэн зохион байгуулах, хөгжүүлэх;

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА 01 ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан, Нийгмийн халамжийн сангийн хөрөнгийн төсөвлөлт, зарцуулалт, тайланг ил тод, нээлттэй болгож, хяналтыг сайжруулах;
- Хүнс, хоол үйлдвэрлэл, дотоод худалдааны бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах;
- Бодлогын хэрэгжилтийн явц, салбарын байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх, үр дүнд үнэлгээ өгөх, төлөвлөлт, гүйцэтгэл, үр ашиг, үр нөлөөг нэмэгдүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хууль;
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль;
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль;
- Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль;
- Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль;
- Нийгмийн халамжийн тухай хууль;
- Ахмад настны тухай хууль;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль;
- Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хууль;
- Олон хүүхэд төрүүлж, өсгөсөн эхийг урамшуулах тухай хууль;
- Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хууль;
- Сангийн сайдын 2023 оны “Ангилал шинэчлэн батлах тухай” 211 дүгээр тушаал.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

ХХҮЕГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр Хяналт шалгалт, дотоод аудит, мониторингийн газрын 2023 оны хяналт шалгалтын төлөвлөгөөг баталж, харьяа 7 аймаг, 3 дүүргийн ХХҮХ-ийн дотоод үйл ажиллагаа, төсвийн үйл ажиллагаа, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт 10, төлөвлөгөөт бус 2 хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэхээр тусгаж, 12 ажлыг бүрэн хэрэгжүүлж, хяналт шалгалтаар нийт 134 зөрчил илрүүлж, хэрэгжилт 90.8 хувьтай, 67 асуудлын хэрэгжилтийн хугацаа болоогүй гэж тайлагнасан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьтай хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

**3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,284,203.5 мянган төгрөгөөр буюу 17.2 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт* /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 3,791.7 | 5,376.9 | 1,585.1 |
| Авлага | 20,837.5 | 34,336.0 | 13,498.6 |
| Бараа материал | 336,620.4 | 324,858.7 | (11,761.7) |
| Үндсэн хөрөнгө | 7,087,148.3 | 8,368,029.8 | 1,280,881.5 |
| **Нийт хөрөнгө** | **7,448,397.9** | **8,732,601.4** | **1,284,203.5** |
| Өр төлбөр | 12,904.5 | 23,454.6 | 10,550.0 |
| Засгийн газрын хувь оролцоо | 7,435,493.4 | 8,709,146.8 | 1,273,653.5 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **7,448,397.9** | **8,732,601.4** | **1,284,203.5** |

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 5,376.9 мянган төгрөг болж, 1,585.1 мянган төгрөгөөр өссөн нь Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7, Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолоор баталсан "Ахмадын сан байгуулан ажиллах журам"-ын 1.2 дахь хэсэг, ХХҮЕГ-ын 2023 оны А/425 дугаар тушаалын дагуу 5,000.0 мянган төгрөгийг ахмадын санд төвлөрүүлснээс зарцуулагдаагүй үлдэгдэл 1,750.0 мянган төгрөг, БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар илгээгдэж буй иргэний үйлчилгээний хураамжийн орлогын гадаад валютын арилжааны харилцах дансны үлдэгдэл 3,626.8 мянган төгрөг тус тус байршиж байна.

Авлага дансны үлдэгдэлд он дамжин бүртгэгдсэн шүүхийн шийдвэрээр ажилгүй байсан хугацааны нөхөн олговор олгосон, буруутай шийдвэр гаргасан албан тушаалтнаар нөхөн төлүүлэх авлага 12,904.5 мянган төгрөг, татаас санхүүжилтийн авлага 21,187.4 мянган төгрөг, хувь хүнээс авах 244.0 мянган төгрөгийн авлага бүртгэлтэй байна.

Бараа материал тайлант онд худалдан авсан бичиг хэрэг, түлш, шатахуун, бусад хангамжийн материалын дүн 88,824.0 мянган төгрөг, ЗГ-ын 2022 оны 417 дугаар тогтоолоор Мэргэжлийн хяналтын ерөнхий газар татан буугдсантай холбоотой шилжүүлэн хүлээн авсан хангамжийн материал 2,461.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, зарцуулсан 103,046.8 мянган төгрөгөөр хасагдсан байна.

Үндсэн хөрөнгө урсгал зардлын төсвөөс бэлтгэсэн 25,440.0 мянган төгрөг, ХНХЯ-ны 2023 оны 03/130 дугаар албан бичиг, ХХҮЕГ-ын 2023 оны А/08 дугаар тушаалаар Азийн хөгжлийн банкны "Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл-2"-ын санхүүжилтээр бэлтгэсэн үнэ төлбөргүй хүлээн авсан тоног төхөөрөмж, программ хангамж 3,194,803.0 мянган төгрөг, Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/855 дугаар захирамж, Өмч хамгаалах газрын 2023 оны 3/962 дугаар тогтоолоор шилжүүлэн авсан хөрөнгө 15,897.9 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, ТӨБЗГ-ын 2023 оны А-1/2026 дугаар тогтоолоор 2 нэр төрлийн 350 ширхэг тоног төхөөрөмжийг аймаг орон нутгийн харьяа газар, хэлтсүүдэд балансаас балансад шилжүүлсэн 514,303.5 мянган төгрөг, ТӨБЗГ-ын 2023 оны 378 дугаар тогтоолоор нийтийн эзэмшлийн төмөр хашаа, явган хүний зам талбайг акталж данснаас хассан 6,885.2 мянган төгрөгөөр тус тус хасагдсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэлд Засгийн газрын 2023 оны 99 дүгээр тогтоолоор Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлэх гадаад ажилтны ажлын байрны төлбөр 10,420.0 мянган төгрөгийг данс андуурч үйл ажиллагааны орлогын дансанд төвлөрүүлснээс үүссэн өглөг, шүүхийн шийдвэрээр ажилгүй байсан хугацааны нөхөн олговор олгосон, буруутай шийдвэр гаргасан албан тушаалтнаар 12,904.5 мянган төгрөгийг нөхөн төлүүлж, хураамжийн орлогын дансанд төвлөрүүлэх өр төлбөр бүртгэлтэй байна.

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01 ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 8,709,146.8 мянган төгрөг болж, 1,273,653.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны санхүүгийн үр дүн болон нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтөөс шалтгаалжээ.

## 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн шууд захирагч 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,952,249.2 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 181,350.0 мянган төгрөг бүрдүүлэхээр, нийт зарлагыг 2,133,599.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлж батлуулсан байна.

Засгийн газрын 2023 оны "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан УИХ-аас баталсан төсвийг 512,597.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, улсын төсвийн санхүүжилтийг 2,481,846.6 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогыг 164,350.0 мянган төгрөг, нийт зарлагыг 2,646,196.6 мянган төгрөгөөр тодотгожээ.

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэх 2,481,846.6 мянган төгрөгийг улсын төсвөөс, 164,350.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн гүйцэтгэлээр тайлант хугацаанд 29,708.0 мянган төгрөгийн дутуу зарцуулалт үүсэж, 208,547.3 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн нь төсвийг бодитой төлөвлөх шаардлага байгааг харуулж байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,480,886.5 мянган төгрөгийн санхүүжилт олгогдож, үндсэн үйл ажиллагааны орлогоос 198,047.5 мянган төгрөг бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,616,488.6 мянган төгрөг буюу 98.9 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 673.0 мянган, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 49,762.0 мянган, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 5,581.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл болон давсан орлого нийт 219,097.3 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл* */мянган төгрөг/*

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|---|
| | Код | Нэр | | | | |
| **Нийт дүн** | | | **2,646,196.6** | **2,616,488.6** | **29,708.0** | **98.9** |
| **1** | **71902** | **Нийгмийн халамж** | **2,063,383.6** | **2,039,629.6** | **23,753.9** | **98.8** |
| 1.1 | 80101 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 1,545,409.1 | 1,492,295.9 | 53,113.2 | 96.6 |
| 1.2 | 80103 | Гэрээгээр гүйцэтгэх ажил, үйлчилгээ | 134,350.0 | 168,047.5 | (33,697.5) | 97.6 |
| 1.3 | 80205 | Мэдээлэл сурталчилгааны зардал | 50,000.0 | 50,000.0 | - | - |
| 1.4 | 80220 | Холбооны суваг ашигласны хөлс | 132,081.1 | 132,081.1 | - | 100.0 |
| 1.5 | 80226 | Байр ашиглалтын үйлчилгээ | 152,501.8 | 149,134.1 | 3,367.7 | 97.8 |
| 1.9 | 80802 | Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг | 49,041.6 | 48,071.0 | 970.6 | 98.0 |
| **2** | **72102** | **Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих** | **582,813.0** | **576,858.9** | **5,954.1** | **99.0** |
| 2.1 | 80101 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 582,813.0 | 576,858.9 | 5,954.1 | 99.9 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

ХНХС, ҮСХ-ны даргын 2023 оны А/161/А/04 дүгээр хамтарсан тушаал, ХХҮЕГ-ын 2023 оны А/84 дүгээр тушаалаар “Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшнийг тодорхойлох хосолмол аргачлалаар нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн мэдээллийг шинэчлэх, мэдээлэл цуглуулах” ажлыг 21 аймаг 9 дүүрэгт зохион байгуулахад 856,793.9 мянган төгрөг, ХХҮЕГ, НДЕГ-ын даргын хооронд 2023 оны 16, 53, НД 87/23, НД88/23 дугаар гэрээ байгуулж 21 аймаг, 9 дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагуудад “Хөдөлмөрийн эрүүл ахуй, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх хяналт хийх, Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх, хяналт хийх” ажлын хүрээнд 64,000.0 мянган төгрөг, НҮБ-ийн Хүүхдийн сангаас нэг цэгийн үйлчилгээний ажлын санхүүжилтэд 8,000.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого 15,272.4 мянган төгрөг, давсан орлого 109,154.5 мянган төгрөг, нийт 1,053,220.8 мянган төгрөгийн нэмэлт орлого бүрдүүлэн, нийт 1,040,908.1 мянган төгрөгийг зарцуулж, 1,675.3 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж, 10,637.4 мянган төгрөгийг татаас санхүүжилтийн авлагаар бүртгэсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01 ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах болон бараа материалын бүртгэл, худалдан авах ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Санхүү-нийцлийн аудитын газрын ахлах аудитор Д.Болор-Эрдэнэ, аудитор Б.Ариунжаргал нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Ц.Хосжаргал, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/118 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "Дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 5,746,879.6 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 57,468.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийгдсэнээр үр дүнгийн тайлангийн нийт зардал 7,379,546.4 мянган төгрөг болж материаллаг зөрүү үүссэн тул материаллаг байдлын түвшнийг шинэчлэн тогтоохоор шийдвэрлэв.

Гүйцэтгэх үе шатанд санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 7,379,546.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар тооцон, 73,795.5 мянган төгрөгөөр материаллаг байдлын түвшнийг шинэчлэн тогтоолоо.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд нийт 159 мэдээлэл байршуулахаас 4 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т *"тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх"*, 6 дугаар зүйлийн 6.4.5-д *"цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр"*, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.4-д *"төрөөс үзүүлж байгаа аливаа ажил, үйлчилгээ, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тэдгээрийн хүрээнд худалдан авч байгаа бараа, ажил, үйлчилгээнд олон нийт хяналт тавих боломжоор хангах"* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг иж бүрэн, хугацаанд нь байршуулж байх зөвлөмж өгөх

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалтуудтай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

**4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

1.ХХҮЕГ болон аймаг, дүүргийн нэгдсэн VPN интернэт сүлжээ болон сумдыг 4G сүлжээнд холбох интернэтээр хангах үндсэн гэрээний 69,930.0 мянган төгрөг, нэмэлт гэрээний 21,915.0 мянган төгрөгийн гэрээт ажлын санхүүжилтэд 108,657.8 мянган төгрөг зарцуулж, 16,812.8 мянган төгрөгийг илүү зарцуулсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-д "Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно", 8.5-д "Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хуваах хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно.", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

**4.5.1 Завсрын аудитын талаар**

Завсрын аудитаар ХХҮЕГ-ын 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг хамруулж, горим сорил хэрэгжүүлсний үр дүнд нийт 7,264,203.9 мянган төгрөгийн 10 алдаа, зөрчил илрүүлж, 194,268.8 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 3,202,491.9 мянган төгрөгийн 2 зөрчилд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, 3,867,443.2 мянган төгрөгийн 7 зөвлөмж хэрэгжүүлээгүйг аудитын тайланд тусгав.

**4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 118,764.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлагыг биелүүлж, 967,365.0 мянган төгрөгийн 4 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, 1 зөвлөмж хэрэгжих шатандаа, хэрэгжилт 60.3 хувьтай байна.

*Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт* */мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Албан шаардлага | 3 | 240,011.8 | 1 | 118,764.0 | 90.0 |
| Зөвлөмж | 5 | 967,365.0 | 4 | 967,365.0 | 30.6 |
| **Нийт дүн** | **8** | **1,207,376.8** | **5** | **1,086,129.0** | **60.3** |

Өмнөх аудитаар өгсөн төрд учруулсан хохирлыг буруутай шийдвэр гаргасан албан тушаалтнаар нөхөн төлүүлэх Нийслэлийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2019 оны 128/ШШ2019/0788 дугаар шийдвэр, ШШЕГ-ын 2022 оны 21290036/138 дугаар албан бичгийг үндэслэн 12,904.5 мянган төгрөгийн авлагыг барагдуулах талаар Төрийн албаны зөвлөлд хандан хамтран ажиллаж, албан шаардлагыг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй хөрөнгөд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх мөн өмнөх аудитаар өгөгдсөн төрд учруулсан хохирлыг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх хувь хүмүүсээс авах 12,904.5 мянган төгрөгийн албан шаардлага хэрэгжих шатандаа байгаа тул дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01 ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайлагналтай холбоотой 2,341,947.8 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын 4 алдаа[1] илрүүлж, аудитын явцад залруулав.

УСНББОУС-1-ийн 27-д "Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой. Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээ, бусад үйл явдал ба нөхцөл байдлуудыг үзэл баримтлалд заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурт нийцүүлэн үнэн зөв илэрхийлэхийг шаарддаг" гэсэнтэй нийцээгүй, санхүүгийн тайлагналын толилуулга батламж мэдэгдлийг хангаагүй дараах алдааг залруулсан. Үүнд:

- Үндсэн үйл ажиллагааны хураамжийн орлого 2,026,597.2 мянган төгрөгийг мөнгөн гүйлгээний тайланд дутуу тайлагнасан;
- Улсын төсвийн санхүүжилтийн орлогыг 182,089.7 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан;
- Нэмэлт санхүүжилтийн тайланд нийт орлогыг 122,090.9 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн;
- Үндсэн үйл ажиллагааны орлогын дансанд ЗГ-ын 2023 оны 99 дүгээр тогтоолоор ХЭДС-д төвлөрүүлэх гадаад ажилтны ажлын байрны төлбөр 10,420.0 мянган төгрөгийн орлогыг бүртгэсэн.

Аудитаар нийт 1,391,433.1 мянган төгрөгийн 14 зөрчил[2] илэрснээс, 224,833.9 мянган төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага, 105,882.8 мянган төгрөгийн 1 хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлж, 1,060,716.4 мянган төгрөгийн зөрчилд 8 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй нийт 1,391,433.1 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан тул "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн.

### 5.1 Албан шаардлага

1. Санхүүгийн тайланд бүртгэлтэй 324,858.7 мянган төгрөгийн бараа материал, 8,368,029.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөд жилийн эцсийн тооллого хийж баталгаажуулаагүй, санхүүгийн тайлан бэлтгэсэн байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах;", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ:" 12.2.1-д "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө;", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 4-т "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх;" гэж заасантай нийцэхгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогыг хийгээгүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх

2. ХХҮЕГ-ын төрийн захиргааны нийт албан хаагчдыг 2023 оны эхний хагас жилд 90-99 хувь буюу "маш сайн" үнэлж 40,858.1 мянган төгрөг, сүүлийн хагас жилд нийт албан хаагчдыг 90.4-99 хувь буюу "маш сайн" үнэлгээгээр үнэлж 69,163.0 мянган төгрөг, нийт 110,021.2 мянган төгрөгийн үр дүнгийн урамшууллыг хавтгайруулан олгосон, сүүлийн хагас жилийн урамшууллыг олгохдоо Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолыг зөрчиж үндсэн цалингийн 100 хувиар тооцон 6,916.3 мянган төгрөгийг илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;", 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах",

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-т "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна." гэж заасантай нийцэхгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Албан хаагчдад урамшууллыг хавтгайруулан олгосон, тогтоосон хувь хэмжээнээс илүү олгосон зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх

3. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин салбарын удирдах ажилтан, албан хаагч нарт сургалт хэлэлцүүлгийн арга хэмжээний зардалд 27,000.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-д “сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэж заасантай нийцэхгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хязгаарлалтыг хэрэгжүүлээгүй, төсвийг хэмнэлтгүй зарцуулсан зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх

4. ХХҮЕГ болон Юнивишн ХХК-ийн хооронд байгуулсан 2021 оны 21/480 дугаар гэрээг үндэслэн лавлах төвийн тусгай дугаар ашиглах ажилд 21,000.0 мянган төгрөг, мэдээлэл сурталчилгаанд 50,000.0 мянган төгрөг, нийт 71,000.0 мянган төгрөгийн ажил үйлчилгээнд төсөвт өртгийг үндэслэлгүй, шууд худалдан авалт хийсэн нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" , Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-д "Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно.", 8.5-д "Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно." гэж заасантай нийцэхгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Нэг төрлийн бараа үйлчилгээний нийт төсөвт өртөгт үндэслэн худалдан авах ажиллагааг зохион байгуулж ажиллаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх

5. Агентлагийн орон тооны дээд хязгаарт багтаагүй орон тооны бус жолооч, харуул, үйлчлэгч зэрэг 9 төрийн үйлчилгээний ажилтанд 105,882.8 мянган төгрөгийн цалинг байр ашиглалтын зардлаас олгож, зориулалт бус зардал гаргаж, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй тул Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-т "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно" гэж заасны дагуу аудитын шийдвэрийг гаргав.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Өмнөх аудитаар хүргүүлсэн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

**5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***Орлогын данстай холбоотой асуудал***

*1.1 Илрүүлэлт:*

Улсын тэмдэгтийн хураамжийн орлогыг тухай бүрд нь бүртгэл хөтөлж, улсын төсвийн орлогын дансанд шилжүүлээгүй 109,154.5 мянган төгрөгийг жилийн эцэст зарцуулагдаагүй төсвийн үлдэгдлийн хамт улсын төсөвт төвлөрүүлсэн, мөн улсын тэмдэгтийн хураамжийн тайланг харьяалагдах татварын албанд хуулийн хугацаанд тушаагаагүй нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх;", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх;", Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-д "Тэмдэгтийн хураамжийн орлогыг улсын болон орон нутгийн төсвийн дансанд тушаах бөгөөд бэлнээр хураасан орлогын хэмжээ 10 000 төгрөг хүрсэн тухай бүрд дансанд тушааж байна.", 43.1-д "Үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь тэмдэгтийн хураамжийн тайланг хагас, бүтэн жилээр гаргах бөгөөд хагас жилийн тайланг жил бүрийн 7 дугаар сарын 20-ны өдрийн дотор, жилийн тайланг дараа оны 02 дугаар сарын 20-ны өдрийн дотор харьяалах татварын албанд гаргаж өгнө." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

*1.2 Өгсөн зөвлөмж:*

Улсын тэмдэгтийн хураамжийн орлогыг тухай бүр улсын төсвийн орлогын дансанд тушаах, хариуцсан нэгж газартай үйлчилгээний орлогын дүнгээр тооцоо нийлсэн акт үйлдэх, харьяалагдах татварын албанд улирал бүр тайлан тушааж байх.

***Бараа материалын данстай холбоотой асуудал***

*2.1 Илрүүлэлт:*

Бараа материалын дансанд 11,293.0 мянган төгрөгийн 36 ширхэг 8 нэр төрлийн үндсэн хөрөнгийн шинжийг хадгалсан тавилга эд хогшил, тоног төхөөрөмж бүртгэлтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай нийцэхгүй байна.

*2.2 Өгсөн зөвлөмж:*

Үндсэн хөрөнгийг шинжтэй хөрөнгүүдийг үндсэн хөрөнгө дансанд шилжүүлэн бүртгэх тайлагнах.

*3.1 Илрүүлэлт:*

Бараа материалын дэлгэрэнгүй тайланд 28812 ширхэг 81,848.3 мянган төгрөгийн 2021 оны эрхийн бичиг, хаяг, засварын материал, оролцоо төсөлтэй холбоотой бараа материал зэрэг хэрэгцээ шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр нөөцөлсөн, бараа материалын тайланд бүртгэлийн хөдөлгөөн хийгдээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай нийцэхгүй байна.

*3.2 Өгсөн зөвлөмж:*

Бараа материалыг хэрэгцээ шаардлагад үндэслэн худалдан авалтыг хийж, нөөц үүсгэхгүй байх

*4.1 Илрүүлэлт:*

Бараа материалын дэлгэрэнгүй тайланд 853.6 мянган төгрөгийн 4 ширхэг барааг 853,600 ширхгээр, үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайланд 331,001.2 мянган төгрөгийн 2 төрлийн программыг 26,178,978 ширхгээр тус тус эхний үлдэгдлээр бүртгэж, бүртгэлийн алдаа гаргаж тайлагнасан байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай нийцэхгүй байна.

*4.2 Өгсөн зөвлөмж:*

Бараа материалын бүртгэлийг бодит тоо хэмжээгээр бүртгэх, бүртгэлд тавих эрх бүхий албан тушаалтныг хариуцлагажуулах

***Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал***

*5.1 Илрүүлэлт:*

Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үлдэх өртөггүй 5,628,979.8 мянган төгрөгийн 3217 ширхэг хөрөнгийн цаашид ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох арга хэмжээ зохион байгуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах;", ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолын 6 дугаар зүйлд "Төрийн өмчийн эд хөрөнгийг акталж, данснаас хасах", 7 дугаар зүйлд "Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох" гэж заасантай нийцэхгүй байна.

*5.2 Өгсөн зөвлөмж:*

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн цаашид ашиглах боломжтой хөрөнгийн судалгаа гаргаж, ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоож, саналыг ТӨБЗГ-т хүргэн шийдвэрлүүлэх

*6.1 Илрүүлэлт*

Программ хангамжийн 502,032.0 мянган төгрөгийн 7 төрлийн программын лицензийн урьдчилгаа төлбөрийг тайлант хугацаанд ногдох зардалд хуваарилан бүртгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай нийцэхгүй байна.

*6.2 Өгсөн зөвлөмж:*

Программын лицензийн урьдчилгаа төлбөрийг улирал бүр зардалд хуваарилан бүртгэж, тайлант хугацааны зардлыг зөв илэрхийлэх

*7.1 Илрүүлэлт*

Үндсэн хөрөнгийн дансанд цаашид ашиглах боломжгүй нийт 13 төрлийн 2,023,090.8 мянган төгрөгийн программ хангамж бүртгэлтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;", ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолын 6 дугаар зүйлд "Төрийн өмчийн эд хөрөнгийг акталж, данснаас хасах", 7 дугаар зүйлд "Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох" гэж заасантай нийцэхгүй байна.

*7.2 Өгсөн зөвлөмж:*

Ашиглагдахгүй программ хангамжийг актлах саналыг холбогдох байгууллагад хүргүүлж, шийдвэрлэх

***Зардлын данстай холбоотой асуудал***

*8.1 Илрүүлэлт*

Тайлант онд төсөв захирагчийн тушаал шийдвэр, гэрээгүй 6,335.0 мянган төгрөгийг урсгал засвар, үйлчилгээний зардалд зарцуулсан, анхан шатны баримтын бүрдэл дутуу 10,777.0 мянган төгрөгийн гүйлгээг зардалд хүлээн зөвшөөрсөн нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэж заасантай нийцэхгүй байна.

*8.2 Өгсөн зөвлөмж:*

Төсөв захирагчийн тушаал, шийдвэрийг үндэслэн хөрөнгө зарцуулж, дотоод хяналтыг сайжруулах

01 ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

9.1 *<u>Илрүүлэлт</u>*

БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллах хүч гаргах, зохион байгуулах үндсэн чиглэлийн үйл ажиллагаанд 14,417.0 мянган төгрөгийн цалин хөлс олгосон нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" ХХҮЕГ-ын даргын 2016 оны А/65 дугаар тушаалаар баталсан "Үйлчилгээний хураамж тогтоох, хураамжийг захиран зарцуулах тухай журам"-ын 3 дахь хэсгийн 3.2-т "Үйлчилгээний хураамжийн зарцуулалтыг Сангийн яамны Төрийн сангийн газраар гүйлгээ хийх эрх нээлгүүлж, БНСУ-д хүргэх албан томилолт, шуудан холбоо, унаа, бичиг хэрэг зэрэг зардалд захиран зарцуулна.", 3.3-т "Үйлчилгээний хураамжийн орлогын зохих хэсгийг байгууллагын холбогдох зардалд захиран зарцуулна." гэж заасантай нийцэхгүй байна.

9.2 *<u>Өгсөн зөвлөмж:</u>*

Үйлчилгээний хураамжийн орлогоос зайлшгүй зарцуулах шаардлагатай зардлыг журамд нэмэлт өөрчлөлт оруулан, батлуулах

10.1 *<u>Илрүүлэлт</u>*

Ердийн галлагаатай сууцанд амьдардаг албан хаагчдад түлээ нүүрсний хөнгөлөлт, ар гэрийн гачигдалтай албан хаагчид буцалтгүй тусламж олгох мөнгөн дүнгийн талаар Хөдөлмөрийн дотоод журамд тусгаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэж заасантай нийцэхгүй байна.

10.2 *<u>Өгсөн зөвлөмж:</u>*

“Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам”-д ажилтан, албан хаагчдад олгох тэтгэмж болон түлээ нүүрсний хөнгөлөлтийг олгох мөнгөн дүнг тодорхой тусгах

11.1 *<u>Илрүүлэлт</u>*

Тайлант хугацаанд дотоод аудит хариуцсан ахлах мэргэжилтэн ХХҮЕГ-ын аппаратын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй, дотоод хяналт, үндсэн хөрөнгөд бүртгэлээр тавигдах хяналт хангалтгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.11-д "төсөв, санхүүгийн дотоод аудит, хяналт шалгалтыг зохион байгуулж, удирдлагаар хангах;", 16 дугаар зүйлийн 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих;", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2-д "Энэ хуулийн 4.1.1-д заасан стандартыг мөрдөх үүрэгтэй аж ахуйн нэгж, байгууллага нь дотоод аудитын нэгжтэй байж болно.", Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоол "Дүрэм батлах тухай" гэж заасантай нийцэхгүй байна.

11.2 *<u>Өгсөн зөвлөмж:</u>*

Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа дахь эрсдэлийг тодорхойлж, эрсдэлд суурилсан дотоод аудитын төлөвлөгөө боловсруулж, батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

*6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл* */мянган төгрөгөөр/*

| Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Алдааны утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс: Залруулсан | | Үүнээс: Залруулаагүй | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | тоо | Дүн | тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 |
| ХХҮЕГ | Үндсэн үйл ажиллагааны хураамжийн орлого 2,026,597.2 мянган төгрөгийг мөнгөн гүйлгээний тайлангаас цэвэрлэж тайлагнасан. | 1 | 2,027,347.2 | | | | | 1 | 2,027,347.2 | | | | |
| | Санхүүгийн тайланд улсын төсвийн санхүүжилтийн орлогыг 182,089.7 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан. | 1 | 182,089.7 | | | | | 1 | 182,089.7 | | | | |
| | Нэмэлт санхүүжилтийн тайланд нийт орлогыг 122,090.9 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн. | 1 | 122,090.9 | | | | | 1 | 122,090.9 | | | | |
| | Байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогын дансанд ЗГ-ын 2023 оны 99 дүгээр тогтоолоор ХЭДС-д төвлөрүүлэх гадаад ажилтны ажлын байрны төлбөр 10,420.0 мянган төгрөгийн орлогыг өглөгөөр бүртгэж тайлагнаагүй байна. | 1 | 10,420.0 | | | | | 1 | 10,420.0 | | | | |
| **Дүн** | | **4** | **2,341,947.8** | - | - | - | - | **4** | **2,341,947.8** | - | - | - | - |

*6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл* */мянган төгрөгөөр/*

| Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Алдаа, зөрчлийн товч утга | Нийт алдаа, зөрчлийн: Тоо | Нийт алдаа, зөрчлийн: Дүн | Үүнээс: Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Хариуцлага тооцох албан шаардлага | | Зөвлөмж | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | | | 9 | 10 | 11 | 12 |
| ХХҮЕГ | Ерөнхий газар, аймаг, дүүргийн нэгдсэн VPN интернэт сүлжээ болон сумдыг 4G сүлжээнд холбох интернэтээр хангах үндсэн гэрээний 69,930.0 мянган төгрөг, нэмэлт гэрээний 21,915.0 мянган төгрөгийн гэрээт ажлын санхүүжилтэд 108,657.8 мянган төгрөг зарцуулж, 16,812.8 мянган төгрөгийг илүү зарцуулсан байна. | 1 | 16,812.8 | | | 1 | 16,812.8 | | | | | | |

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Санхүүгийн тайланд бүртгэлтэй 324,858.7 мянган төгрөгийн бараа материал, 8,368,029.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөд жилийн эцсийн тооллого хийж баталгаажуулаагүй, санхүүгийн тайлан бэлтгэсэн байна. | 1 | - | | | 1 | - | | | | | | |
| | ХХҮЕГ-ын төрийн захиргааны нийт албан хаагчдыг 2023 оны эхний хагас жилд 90-99 хувь буюу "маш сайн" үнэлж 40,858.1 мянган төгрөг, сүүлийн хагас жилд нийт албан хаагчдыг 90.4-99 хувь буюу "маш сайн" үнэлгээгээр үнэлж 69,163.0 мянган төгрөг, нийт 110,021.2 мянган төгрөгийн үр дүнгийн урамшууллыг хавтгайруулан олгосон, сүүлийн хагас жилийн урамшууллыг олгохдоо Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолыг зөрчиж үндсэн цалингийн 100 хувиар тооцон 6,916.3 мянган төгрөгийг илүү олгосон байна. | 1 | 110,021.1 | | | 1 | 110,021.1 | | | | | | |
| | ХХҮЕГ болон Юнивишн ХХК-ийн хооронд байгуулсан 2021 оны 21/480 дугаар гэрээг үндэслэн лавлах төвийн тусгай дугаар ашиглах ажилд 21,000.0 мянган төгрөг, мэдээлэл сурталчилгаанд 50,000.0 мянган төгрөг, нийт 71,000.0 мянган төгрөгийн ажил үйлчилгээнд төсөвт өртгийг үндэслэлгүй, шууд худалдан авалт хийсэн. | 1 | 71,000.0 | | | 1 | 71,000.0 | | | | | | |
| | Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин салбарын удирдах ажилтан, албан хаагч нарт сургалт хэлэлцүүлгийн арга хэмжээний зардалд 27,000.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна. | 1 | 27,000.0 | | | 1 | 27,000.0 | | | | | | |
| | Өмнөх аудитаар өгөгдсөн агентлагийн орон тооны дээд хязгаарт багтаагүй орон тооны бус жолооч, харуул, үйлчлэгч зэрэг 9 төрийн үйлчилгээний ажилтанд 105,882.8 мянган төгрөгийн цалинг | 1 | 105,882.8 | | | | | 1 | 105,882.8 | | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | байр ашиглалтын зардлаас олгож, зориулалт бус зардал гаргасан албан шаардлагын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй байна. | | | | | | | | | | | | |
| | Улсын тэмдэгтийн хураамжийн орлогыг тухай бүр бүртгэл хөтөлж, улсын төсөвт тушаагаагүй 109,154.5 мянган төгрөгийг зарцуулагдаагүй үлдэгдлээр татуулсан, мөн тэмдэгтийг хураамжийн тайланг харьяалагдах татварын албанд хуулийн хугацаанд тушаагаагүй. | 1 | 109,154.5 | | | | | | | 1 | 109,154.5 | | |
| | Бараа материалын дансанд 11,293.0 мянган төгрөгийн 36 ширхэг 8 нэр төрлийн үндсэн хөрөнгийн шинжийг хадгалсан тавилга эд хогшил, тоног төхөөрөмж бүртгэсэн байна. | 1 | 11,293.0 | | | | | | | 1 | 11,293.0 | | |
| | Бараа материалын дэлгэрэнгүй тайланд 28812 ширхэг 81,848.3 мянган төгрөгийн 2021 оны эрхийн бичиг, хаяг, засварын материал, оролцоо төсөлтэй холбоотой бараа материал зэрэг хэрэгцээ шаардлагагүй бараа бүтээгдэхүүнийг их хэмжээгээр нөөцөлж, бараа материалын тайланд бүртгэлийн хөдөлгөөн хийгдээгүй байна. | 1 | 89,270.0 | | | | | | | 1 | 89,270.0 | | |
| | Бараа материалын дэлгэрэнгүй тайланд 853.6 мянган төгрөгийн 4 ширхэг барааг 853,600 ширхгээр, үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайланд 331,001.2 мянган төгрөгийн 2 төрлийн программыг 26,178,978 ширхгээр тус тус эхний үлдэгдлээр бүртгэж, бүртгэлийн алдаа гаргаж тайлагнасан байна. | 1 | 331,854.8 | | | | | | | 1 | 331,854.8 | | |
| | Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үлдэх өртөггүй 5,628,979.8 мянган төгрөгийн 3217 ширхэг хөрөнгөнд дахин үнэлгээ хийгдээгүй, арга хэмжээ авч ажиллаагүй байна. | 1 | - | | | | | | | 1 | - | | |
| | Программ хангамжийн 502,032.0 мянган төгрөгийн 7 төрлийн | 1 | 502,032.0 | | | | | | | 1 | 502,032.0 | | |

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01 ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | программын лицензийн урьдчилгаа төлбөрийг тайлант хугацаанд ногдох зардлыг хуваарилан бүртгээгүй. | | | | | | | | | | |
| | Үндсэн хөрөнгийн дансанд цаашид ашиглах боломжгүй нийт 13 төрлийн 2,023,090.8 мянган төгрөгийн программ хангамж бүртгэлтэй байна. | 1 | - | | | | | | 1 | - | | |
| | Тайлант онд төсөв захирагчийн тушаал шийдвэр, гэрээгүй 6,335.0 мянган төгрөгийг урсгал засвар үйлчилгээний зардалд зарцуулсан, анхан шатны баримтын бүрдэл дутуу 10,777.0 мянган төгрөгийн зардал гаргаж бүртгэсэн байна. | 1 | 17,112.0 | | | | | | 1 | 17,112.0 | | |
| **Дүн** | | **14** | **1,391,433.1** | **-** | **-** | **5** | **224,833.9** | **1** | **105,882.8** | **8** | **1,060,716.4** | **-** | **-** |

*6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал* */мянган төгрөгөөр/*

| Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Алдаа, зөрчлийн товч утга | Нийт алдаа, зөрчлийн дүн | | Үүнээс: | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Тоо | Дүн | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
| ХХҮЕГ | БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллах хүч гаргах, зохион байгуулах үндсэн чиглэлийн үйл ажиллагаанд 14,417.0 мянган төгрөгийн цалин хөлс олгосон нь холбогдох журмын 3.2-т заасантай нийцэхгүй байна. | 1 | - | | | | | 1 | - |
| | Ердийн галлагаатай сууцанд амьдардаг албан хаагчдад түлээ нүүрсний хөнгөлөлт, ар гэрийн гачигдалтай албан хаагчид буцалтгүй тусламж олгох мөнгөн дүнгийн талаар Хөдөлмөрийн дотоод журамд тусгаагүй байна. | 1 | - | | | | | 1 | - |
| | Тайлант хугацаанд дотоод аудит хариуцсан ахлах мэргэжилтэн ХХҮЕГ-ын аппаратын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй, дотоод хяналт, үндсэн хөрөнгөд бүртгэлээр тавигдах хяналт хангалтгүй байна. | 1 | - | | | | | 1 | - |
| | Шилэн дансны цахим хуудсанд 159 мэдээлэл байршуулахаас 4 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. | 1 | - | | | | | 1 | - |
| **Дүн** | | **4** | **-** | **-** | **-** | **-** | **-** | **4** | **-** |

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2024 оны 02 дугаар сарын 23 №247/А16 0067 Улаанбаатар хот
СНАГ-2024/70/НА-СТА-ТЖШ3

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар болон аймаг, дүүргийн нэгдсэн VPN интернэт сүлжээ болон сумдыг 4G сүлжээнд холбох интернэтээр хангах үндсэн гэрээний 69,930,000.00 /жаран есөн сая есөн зуун гучин мянган/ төгрөг, нэмэлт гэрээний 21,915,000.00 /хорин нэгэн мянга есөн зуун арван таван мянган/ төгрөгийн гэрээт ажлын санхүүжилтэд 108,657,769.49 /нэг зуун найман сая зургаан зуун тавин долоон мянга долоон зуун жаран есөн/ төгрөг зарцуулж, 16,812,769.49 /арван зургаан сая найман зуун арван хоёр мянга долоон зуун жаран есөн/ төгрөгийг илүү зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д *"санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;"*, 6 дугаар зүйлийн 6.4.1-д *"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;"* , Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-д *"Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно."*, 8.5-д *"Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хуваах хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно."*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д *"Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно."* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө"*, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.4-т *"төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн;"* " заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /З.Энхболд/, Төсвийн үйл ажиллагааны мэргэжилтэн, нягтлан бодогч /А.Мөрөнгоо/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР Ц.ХОСЖАРГАЛ
АХЛАХ АУДИТОР Д.БОЛОР-ЭРДЭНЭ
АУДИТОР Б.АРИУНЖАРГАЛ

АТА9693 9006109
9023030583

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2024\0223 SNAG-70.Docx

0001080608

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2024 оны 02 дугаар сарын 23 №248/А160067
СААГ-2024/70/НА-СТА-ТНЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Санхүүгийн тайланд бүртгэлтэй 324,858,677.74 /гурван зуун хорин дөрвөн сая найман зуун тавин найман мянга зургаан зуун далан долоон/ төгрөгийн бараа материал, 8,368,029,811.79 /найман тэрбум гурван зуун жаран найман сая хорин есөн мянга найман зуун арван нэгэн/ төгрөгийн үндсэн хөрөнгөд жилийн эцсийн тооллого хийж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д *"төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах;"*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д *"Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна."*, 12.2-д *"Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ:"* 12.2.1-д *"жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө;"*, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 4-т *"комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх;"* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө"*, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.2-т *"хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй;"* гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого хийж, баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /З.Энхболд/, Төсвийн үйл ажиллагааны мэргэжилтэн, нягтлан бодогч /А.Мөрөнгоо/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

| | |
|---|---|
| САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР | Ц.НАРАНЧИМЭГ |
| АУДИТЫН МЕНЕЖЕР | Ц.ХОСЖАРГАЛ |
| АХЛАХ АУДИТОР | Д.БОЛОР-ЭРДЭНЭ |
| АУДИТОР | Б.АРИУНЖАРГАЛ |

АТА9693 9006109
9023030563

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

Z:\Alban Shaardlaga\2024\0223 SNAG-70.Docx

0001080600

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2024 оны 02 дугаар сарын 23 № 249/А160067 Улаанбаатар хот
СНАГ-2024/70/НА-СТА-ТМШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын төрийн захиргааны нийт албан хаагчдыг 2023 оны эхний хагас жилд 90-99 хувь буюу "маш сайн" үнэлж 40,858,100.00 /дөчин сая найман зуун тавин найман мянга нэг зуун/ төгрөг, сүүлийн хагас жилд 90.4-99 хувь буюу "маш сайн" үнэлгээгээр үнэлж 69,163,000.00 /жаран есөн сая нэг зуун жаран гурван мянган/ төгрөг, нийт 110,021,200.00 /нэг зуун арван сая хорин нэгэн мянга хоёр зуун/ төгрөгийн үр дүнгийн урамшууллыг хавтгайруулан олгосон, сүүлийн хагас жилийн урамшууллыг олгохдоо үндсэн цалингийн 100.0 хувиар тооцон 6,916,300.00 /зургаан сая есөн зуун мянга арван зургаан мянга гурван зуун/ төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д *"санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;"*, 16.5.5-д *"батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"*, 16.5.7-д *"байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах"*, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-т *"Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна."* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө"*, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.4-т *"төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн;"* гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Албан хаагчдад урамшууллыг хавтгайруулан, тогтоосон хувь хэмжээнээс илүү олгосон зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /З.Энхболд/, Төсвийн үйл ажиллагааны мэргэжилтэн, нягтлан бодогч /А.Мөрөнгоо/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР Ц.ХОСЖАРГАЛ
АХЛАХ АУДИТОР Д.БОЛОР-ЭРДЭНЭ
АУДИТОР Б.АРИУНЖАРГАЛ

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

Z:\Alban Shaardlaga\2024\0223 SNAG-70.Docx

0001080607

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**АЛБАН ШААРДЛАГА**

2024 оны 02 дугаар сарын 23 № 250/А160067

СНАГ-2024/70/НА-СПА-ПШЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж удирдах ажилтан, албан хаагч нарт сургалт хэлэлцүүлгийн арга хэмжээний зардалд 27,000,000.00 /хорин долоон сая/ төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т *"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;"*, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-д *"сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх;*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д *"Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно."* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө"*, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т *"Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн нөхцөл байдал"* гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасныг хэрэгжүүлээгүй, төсвийн хэмнэлтийн бодлого баримталж ажиллаагүй зарцуулсан зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /З.Энхболд/, Төсвийн үйл ажиллагааны мэргэжилтэн, нягтлан бодогч /А.Мөрөнгоо/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР — Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР — Ц.ХОСЖАРГАЛ
АХЛАХ АУДИТОР — Д.БОЛОР-ЭРДЭНЭ
АУДИТОР — Б.АРИУНЖАРГАЛ

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264250*

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**
**АЛБАН ШААРДЛАГА**

2024 оны 02 дугаар сарын 23 № 251/А160067 СНАГ-2024/70/НА-СПА-ТНЩ3 Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга Юнивишн ХХК-ийн хооронд байгуулсан 2021 оны 21/480 дугаар гэрээг үндэслэн лавлах төвийн тусгай дугаар ашиглах, техник хяналтын туслалцаа үзүүлэх багцын ажилд 21,000,000.00 /хорин нэгэн сая/ төгрөг, мэдээлэл сурталчилгааны зардалд 50,000,000.00 /тавин сая/ төгрөг, нийт 71,000,000.00 //далан нэгэн сая/ төгрөгийн нэг төрлийн бараа, ажил үйлчилгээнд төсөвт өргийг үндэслэлгүй шууд худалдан авалт хийж, худалдан авах ажиллагааг зөрчсөн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д *"санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;"*, 6 дугаар зүйлийн 6.4.1-д "*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;*" , Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-д *"Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно."*, 8.5-д *"Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нэлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно."* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө"*, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-д *"Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол;"* "гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нэг төрлийн бараа үйлчилгээг хэсэгчлэн хувааж, шууд худалдан авалт хийсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /З.Энхболд/, Төсвийн үйл ажиллагааны мэргэжилтэн, нягтлан бодогч /А.Мөрөнгоо/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

| | |
|---|---|
| САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР | Ц.НАРАНЧИМЭГ |
| АУДИТЫН МЕНЕЖЕР | Ц.ХОСЖАРГАЛ |
| АХЛАХ АУДИТОР | Д.БОЛОР-ЭРДЭНЭ |
| АУДИТОР | Б.АРИУНЖАРГАЛ |

ATA9693 9006184 9023030583

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

Z:\Alban Shaardlaga\2024\0223 SNAG-70.Docx

0001080606

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**АЛБАН ШААРДЛАГА**

2024 оны 02 дугаар сарын 23 № 252/А160067

СНАГ-2024/70/НА/СТМ-ТНШ3

Улаанбаатар хот

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх аудитаар өгсөн 2023 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн 717/А160065 дугаар албан шаардлагын агентлагийн орон тооны дээд хязгаарт багтаагүй орон тооны бус жолооч, харуул, үйлчлэгч зэрэг 9 төрийн үйлчилгээний ажилтанд 105,882,800.00 /нэг зуун таван сая найман зуун наян хоёр мянга найман зуун/ төгрөгийн цалинг байр ашиглалтын зардлаас зориулалт бус зарцуулж, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-т *"батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох"*, 16.5.5-д *"батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"* заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т "*Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ*", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.2-т *"Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд "Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага" хүргүүлнэ."* гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх аудитаар хүргүүлсэн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй холбогдох албан тушаалтанд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /З.Энхболд/-д даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

| | |
|---|---|
| САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР | Ц.НАРАНЧИМЭГ |
| АУДИТЫН МЕНЕЖЕР | Ц.ХОСЖАРГАЛ |
| АХЛАХ АУДИТОР | Д.БОЛОР-ЭРДЭНЭ |
| АУДИТОР | Б.АРИУНЖАРГАЛ |

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

Утас: +976 51 261585
Факс: +976 11 323266, 324653

Цахим шуудан: info@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

Хаяг: Засгийн газрын IV байр
Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг
Улаанбаатар-15160, Монгол Улс